



## ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 10 сарын 23 өдөр

Дугаар А/54

Улаанбаатар хот

### Хөрөнгө гаргах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь заалт, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 4.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 7.1 дүгээр зүйлийн 1.5 дахь заалт, “Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны зардал тооцох журам”-ын 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Сангийн сайдын 2023 оны А/78 дугаар тушаалаар батлагдсан “Хөрөнгийн үнэлгээний үйлчилгээний хөлсний жишиг”, Газрын дүрмийн 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Тус газрын эрх бүхий албан тушаалтны Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны зардал, хохирлын нөхөн төлбөрийн хэмжээг тооцуулах шинжээч (төсөвчин, үнэлгээчин)-ийг ажиллуулахад шаардагдах зардлын задаргааг хавсралтаар баталсугай.

2.Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны зардал, шинжээч (төсөвчин, үнэлгээчин)-ийн үйл ажиллагаанд шаардагдах 750,000 (Долоон зуун тавин мянга) төгрөгийн зардлыг Бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардлаас гаргахыг Агентлаг хариуцсан ахлах нягтлан бодогч (Б.Түмэнжин)-д зөвшөөрсүгэй.

3.Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны зардал, шинжээч (төсөвчин, үнэлгээчин)-ийн үйл ажиллагаанд хяналт тавих, удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллахыг Дэд бүтцийн стандарт, хяналтын хэлтэс (Б.Найрамдал)-т үүрэг болгосугай.

ДАРГА

  
С.ТӨМӨРДУЛАМ

